



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 09 сарын 08 өдөр

Дугаар 414

Улаанбаатар хот

Төрийн өмчийн төлөөлөгчийг томилж, удирдамж батлах тухай


Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам”-ын 2.10, 4.1.1, 4.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцох төрийн өмчийн төлөөлөгчөөр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэ, ахлах мэргэжилтэн В.Дарханбаатар нарыг томилсугай.

2.Төрийн өмчийн төлөөлөгчийн баримтлах удирдамжийг хавсралтаар баталсугай.

3.Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд удирдамжийг баримтлан оролцох, хуралд оролцсон тайланг танилцуулахыг төрийн өмчийн төлөөлөгч нарт даалгасугай.

ДАРГА  Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА  Ц.БАЯР-ЭРДЭНЭ

900875

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн
...414... дугаар тогтоолын хавсралт

**“ХӨШИГИЙН ХӨНДИЙН НИСЭХ ОНГОЦНЫ БУУДАЛ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРАЛД
ТӨРИЙН ӨМЧИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН БАРИМТЛАХ УДИРДАМЖ**

Төрийн өмчийн төлөөлөгч нь компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудлаар шийдвэр гаргахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйл, “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам” болон дараах удирдамжийг баримтална:

-Монгол Японы хамтарсан “Нью Улаанбаатар интернэйшнл эйрпорт” ХХК-д оруулсан хөрөнгө оруулалт болон бусад эх үүсвэрээр хийгдсэн нийт 49,373,854,200.0 (дөчин есөн тэрбум гурван зуун далан гурван сая найман зуун тавин дөрвөн мянга хоёр зуун) төгрөгийн эх үүсвэрийн дүнгээр “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн эзэмшигчийн өмч дэх төрийн өмчийн дүнг нэмэгдүүлэхийг зөвшөөрөх.

-“Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмийн 3.1 дэх заалтанд “Компанийн өөрийн хөрөнгө хувьцаанаас бүрдэх бөгөөд нэг бүр нь 100 (нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 10000 (арван мянган) ширхэг энгийн хувьцаатай байна” гэснийг “Компанийн өөрийн хөрөнгө хувьцаанаас бүрдэх бөгөөд нэг бүр нь 100 (нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 493,748,542 (дөрвөн зуун ерин гурван сая долоон зуун дөчин найман мянга таван зуун дөчин хоёр) ширхэг энгийн хувьцаатай байна” гэж өөрчлөх.

-“Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн эзэмшигчийн өмч дэх төрийн өмчийн дүнд орсон өөрчлөлтийг холбогдох байгууллагад бүртгүүлэхийг гүйцэтгэх захирал Л.Цэнгүүнжавт үүрэг болгох.

-----oOo-----